

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХШҮХ-ЭЭС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ  
БОЛОВСРУУЛСАН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023.01.06

д/д	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	Хувь
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авах талаарх аймгийн Засаг даргын 2015 оны а/149 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цахим мэдээллийн сан бүрдүүлэлтэд анхаарч ажиллах;	Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийг хангах хүрээнд байгууллагын гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулан мэргэжилтнүүдэд танилцуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Байгууллагад ирсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг аймгийн Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/149 дүгээр захирамжаар батлагдсан “Хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих, мэдээлэх, тайлагнах журам”-ын дагуу бүртгэж, албан тушаалтанд танилцуулах хуудсаар танилцуулж, шаардлагатай шийдвэрүүдэд хувийн нээн эзэнжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Биелэлтийг ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-дагуу хэрэгжилтийг тооцон аймгийн Засаг даргын Тамгын газрын ХБТХОХэлтэст тогтоосон хугацаанд тайлагнасан.	100
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг ханган ажиллах;	Байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан ажилтай холбоотой салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар зорилт, арга хэмжээ тусгаж үр дүнг тооцон хяналт тавьж ажилласан.	100
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн тайлагналтын үр дүн, үр нөлөөнд тулгуурлаж бичих чадварт бүх албан хаагчдыг сургах чадавхжуулах;	ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” ЗГ-ын 2021 оны 374	70

		дүгээр тогтоолуудыг танилцуулах дотоод сургалтыг 2 удаа зохион байгуулсан.	
4	Тайлангийн хэрэгжилтийг дүгнэхдээ суурь түвшинг зорилтот түвшинтэй харьцуулах, бодит үр дүнг тооцоход анхаарч ажиллах;	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн дүгнэхдээ журамд заасан аргачлалын дагуу тооцсон.	100
5	Байгууллагын албан хаагчдын баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт, нотолгоонд тулгуурлан үнэн зөв, товч тодорхой тайлагнах ур чадварыг нэмэгдүүлэх;	Албан хаагчдын баримт бичиг боловсруулах чадварыг дээшлүүлэх зорилгоор шинээр батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хууль, ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны с/30 дугаар тушаалаар батлагдсан MNS 5140-2:2021 стандарт, ЗГ-ын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-уудыг цахим сайтуудаас татаж авч гарын авлага болгон ашиглаж байна. Албан хэрэг хөтлөлтийн шинэ хууль дүрэм журмыг танилцуулах дотоод сургалтын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж, тус газрын мэргэжилтнүүд, сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, Сум дундын Ойн ангийн албан хаагчид нийт 50 хүн оролцсон.	100
6	Байгууллагын албан ёсны вэйб сайтыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх, сайтыг хөгжүүлэх, мэдээ мэдээллийг шинэчлэх, хэвийн үйл ажиллагааг хариуцан ажиллах албан хаагчийг тодорхой болгож админ эрхийг олгох, хэрэглэгч мэдээлэл авахад ойлгомжтой хялбар болгох, ил тод байдлыг хангаж ажиллах;	Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийг хангах хүрээнд байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд ил тод, нээлттэй байлгах нөхцлийг бүрдүүлж <a href="http://nature.ov.gov.mn">nature.ov.gov.mn</a> байгууллагын албан ёсны вэйб сайтыг шинээр хийлгүүлж, мэдээ мэдээллийг шинэчлэн ил тод байдлыг ханган ажиллалаа. Вэйб сайтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, уг сайтыг хариуцан ажиллах мэргэжилтэнг сургалтад хамруулж, сайт хийлгэх зардлыг байгууллагын төсвийн боломжид тулгуурлан шийдвэрлэлээ.	100
7	Байгууллагын цахим сайтад авлигын чиглэлээр цэс нээж авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр мэдээ мэдээлэл байршуулах;	-Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор байгууллагын <a href="http://nature.ov.gov.mn">nature.ov.gov.mn</a> вэйб сайтны ил тод байдал цонхонд Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэсэн цонх нээж, Авлигын эсрэг хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөөг оруулж, Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллагуудаас гаргасан төрөл бүрийн шторик, постер, гарын авлага мэдээллүүдийг байршуулж иргэд олон нийтэд хүргэж байна.	100

		-Төрийн албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Авлига түүний хор нөлөө” сэдэвт сургалтыг зохион байгуулж, тус газрын мэргэжилтнүүд болон сумдын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагчдыг хамрууллаа. Уг сургалтын сургагч багшаар аймгийн ИТХ-ын Хүний нөөцийн мэргэжилтэн, АТГ-ын Авлигын эсрэг сургагч багш М.Мөнхсүрэн ажиллаж мэдээлэл өглөө.	
8	Байгууллагын шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж ажиллах, хөтлөлтөд хяналт тавьж ажиллах;	Байгууллагын тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл сар, улирлын мэдээ болон төсөвт орсон өөрчлөлт болон бусад мэдээ мэдээллийг тухай бүр шилэн дансанд оруулж, мэдээллийн самбарт байршуулах ажлыг нягтлан бодогч хариуцан хөтлөлтөд дотоод хяналтын нэгж хяналт тавьж ажиллалаа.	100
9	Төрийн албан хаагч бүр хариуцсан ажлын хүрээнд судалгаа, мэдээллийн сантай байх;	Тус газрын мэргэжилтнүүд хариуцсан ажлын чиглэлээр судалгаа мэдээлэл болон хуулийн мэдээллийн сантай бөгөөд баяжилтыг тухай бүр хийж, тухайн жилд хөтлөгдсөн баримт бичгүүдийг хөтлөх хэргийн нэрийн загсаалтын дагуу байгууллагын архивт цахим болон цаасан хэлбэрээр хүлээлгэн өгсөн.	100
10	МУ-ын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхтэй холбогдуулан ЗГ-ын 374 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийг агентлагийн хэмжээнд нэгтгэн, хэрэгжилтийг ханган ажиллах (Ногоон байгууламж, хог хаягдлын менежмент)	МУ-ын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхтэй холбогдуулан аймгийн ИТХ-аас 2022 оныг “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” зорилтот жил болгон зарлаж, зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. ЗГ-ын 374 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийг ногоон байгууламж, хог хаягдлын менежмент гэсэн 2 чиглэлээр агентлагийн хэмжээнд нэгтгэсэн.	100
11	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх ЗГ-ын 246 дугаар тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан Баримт бичгийн стандарт (MNS5140;2021), 2022 оны С/13 дугаар тушаалаар батлагдсан Монгол бичгээр үйлдэх	-“Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хууль, ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны с/30 дугаар тушаалаар батлагдсан MNS 5140-2:2021 стандарт, 2022 оны С/13 дугаар тушаалаар батлагдсан Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага (MNS6395;2022) стандарт, ЗГ-ын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-уудыг байгууллагын үйл	100

	<p>баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага (MNS6395;2022), -ын хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>	<p>ажиллагаандаа мөрдөж ажиллах хүрээнд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Архив-бичиг хэргийн ажилтан ахлах мэргэжилтэнтэй хамтран боловсруулж, байгууллагын Архив-албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын ажлын дүрмийг шинэчлэн боловсруулж газрын даргын 2022 оны А/02 тушаалаар батлууллаа. Батлагдсан стандартуудын дагуу байгууллагын хэвлэмэл хуудасны эхийг Архивын Ерөнхий газраар бэлтгүүлж, хэвлэлийн үйлдвэрээр хэвлүүлж ашиглаж байна.</p> <p>Тус газрын Архив-бичиг хэргийн ажилтныг аймгийн Архивын тасгаас зохион байгуулсан “Архив албан хэрэг хөтлөлт”-ийн сургалт, Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан “Монгол бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих бэлтгэл ажлыг хангах” талаарх сургалтад тус тус хамруулж монгол бичгийн программыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд туршилтаар нэвтрүүлэхээр монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудсыг хэвлүүлэн, программыг суулгаад байна.</p>	
Дундаж үнэлгээ			97,2

БИЕЛЭЛТ ХЯНАСАН  
 БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
 ГАЗРЫН ДАРГА

Г.БАЯСГАЛАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН  
 БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД  
 АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛЗАЯА

БАТЛАВ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА

Г.БАЯСГАЛАН

.....ны.....дугаар сарын.....-ны өдөр

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ  
ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.05.20

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авах талаарх аймгийн Засаг даргын 2015 оны а/149 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цахим мэдээллийн сан бүрдүүлэлтэд анхаарч ажиллах;	Жилдээ	Архив, бичиг хэргийн ажилтан Мэргэжилтнүүд
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг ханган ажиллах;	Жилдээ	-Ахлах мэргэжилтэн Э.Золзаяа  -Мэргэжилтнүүд
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн тайлагналтын үр дүн, үр нөлөөнд тулгуурлаж бичих чадварт бүх албан хаагчдыг сургах чадавхжуулах;	Жилдээ	Удирдлага Мэргэжилтнүүд
4	Тайлангийн хэрэгжилтийг дүгнэхдээ суурь түвшинг зорилтот түвшинтэй харьцуулах, бодит үр дүнг тооцоход анхаарч ажиллах;	Жилдээ	Мэргэжилтнүүд
5	Байгууллагын албан хаагчдын баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт, нотолгоонд тулгуурлан үнэн зөв, товч тодорхой тайлагнах ур чадварыг нэмэгдүүлэх;	Жилдээ	Мэргэжилтнүүд
6	Байгууллагын албан ёсны вэйб сайтыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх, сайтыг хөгжүүлэх, мэдээ мэдээллийг шинэчлэх, хэвийн	Жилдээ	Удирдлага Мэргэжилтэн Ц.Болдбаатар

	үйл ажиллагааг хариуцан ажиллах албан хаагчийг тодорхой болгож админ эрхийг олгох, хэрэглэгч мэдээлэл авахад ойлгомжтой хялбар болгох, ил тод байдлыг хангаж ажиллах;		
7	Байгууллагын цахим сайтад авлигын чиглэлээр цэс нээж авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр мэдээ мэдээлэл байршуулах;	Жилдээ	Мэргэжилтэн Э.Золзаяа Ц.Болдбаатар
8	Байгууллагын шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж ажиллах, хөтлөлтөд хяналт тавьж ажиллах;	Жилдээ	Нягтлан бодогч Дотоод хяналтын нэгж
9	Төрийн албан хаагч бүр хариуцсан ажлын хүрээнд судалгаа, мэдээллийн сантай байх;	Жилдээ	Бүх албан хаагчид
10	МУ-ын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхтэй холбогдуулан ЗГ-ын 374 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийг агентлагийн хэмжээнд нэгтгэн, хэрэгжилтийг ханган ажиллах (Ногоон байгууламж, хог хаягдлын менежмент)	Жилдээ	Холбогдох мэргэжилтнүүд
11	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх ЗГ-ын 246 дугаар тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан Баримт бичгийн стандарт (MNS5140;2021)-ын хэрэгжилтийг хангаж ажиллах. Тухайлбал:Хуралдааны тэмдэглэл, зөвлөмж, илтгэх хуудас зэргийг стандартын шаардлагад нийцүүлэх.	Жилдээ	Архив бичиг хэргийн ажилтан Мэргэжилтнүүд

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД  
АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛЗАЯА

